

МОНГОЛ ЛИМБЭЧДИЙН “УРТЫН ДУУ ЛИМБЭДЭХ УЛАМЖЛАЛТ АРГА БИТҮҮ АМЬСГАА” ӨВИЙГ ӨВЛӨН СУРАЛЦАГЧДЫН АНХДУГААР УРАЛДААНЫ ТАЙЛАН

ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Монгол ардын уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгаа” төслийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

Уг төслийн хэрэгжилт, үр дүнг олон нийтэд сурталчлах, шавь сургалтын үр дүнг тайлагнах, лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа өвийн оршин тогтнох чадварыг тогтворжуулах зорилгоор Соёлын өвийн үндэсний төв, Монголын лимбэчдийн холбоотой хамтран 2022 оны 06 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд “Монгол лимбэчдийн ”Уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү-амьсгаа” уралдааныг Соёлын өвийн үндэсний төвд зохион байгууллаа. Тус уралдаанд нийслэл Улаанбаатар хотоос 4-н багштай 11-н суралцагч, орон нутгаас Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай зэрэг 7-н аймгийн 7-н багштай 15-н суралцагчид, цахимаар 6-н суралцагч тус тус хамрагдаж нийт 11 багшийн 40 суралцагч буюу 13 - 43 насны эмэгтэй 7, эрэгтэй 33 суралцагчид оролцлоо.

Уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгуулж I шатанд оролцсон нийт 40 оролцогчоос II шатанд 14 суралцагч авьяас, ур чадвараараа өрсөлдснөөс тэргүүн байр -1, дэд байр-1, гутгаар байр байр-1, тусгай байр 2, шилдэг багш 2-г тус тус шалгаруулж суралцагчдыг өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулав. Үүнд:

Анхдугаар уралдааны тэргүүн байранд Өмнөговь аймгаас оролцогч МУСГЗ Ө.Батжаргал багшийн шавь Батбаярын Энхжин, Дэд байранд Дорноговь аймгаас оролцогч МУСТА Б.Отгондүү багшийн шавь Ариунцэцэгийн Уранжаргал, Гутгаар байранд Дорноговь аймгаас оролцогч МУСТА Б.Отгондүү багшийн шавь Төмөрбаатарын Тогтохбаяр, Тусгай байранд Чүлтэмсүрэнгийн Даваажав багшийн шавь Гантөмөрийн Төмөржин, Мишигдоржийн Цэнгэлсайхан багшийн шавь Мэндбаярын Жигмэдсэрчин нар тус тус байр эзэлж, шилдэг багшаар МУСГЗ Өлзийн Батжаргал, МУСТА Буяндэлгэрийн Отгондүү нар шалгарлаа..

Цаашид лимбэ хөгжмөөр суралцагчдын залгамж холбоог таслахгүйгээр боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор СУИС-ийн захиргаанаас уралдаанд амжилт гарган оролцсон ЕБС-ийн 11, 12 дугаар төгсөх ангийн төгсөгч Сэлэнгэ аймгийн ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагч А. Золбоот, Улаанбаатар хотын ЕБС-ийн сурагч Э. Алтангэрэл, Хөвсгөл аймгийн ЕБС-ийн сурагч Н. Одбаяр зэрэг суралцагчдад

тус сургуулийн лимбэний ангид ур чадварын шалгалтгүйгээр дэвшин суралцах батламж олгосон нь энэхүү өвийг цаашид оршин тогтнох чадварт эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой юм. Мөн төслийн үр дүнд Өмнөговь, Ховд аймгийн ЕБС-д, Соёлын Урлагийн их сургууль, Монгол Улсын Завхан аймгийн Хөгжим Бүжгийн коллеж зэрэг 5 аймагт Лимбэ хөгжмийн ангийг шинээр нээсэн нь хөдөө орон нутагт сонирхогч, суралцагчдын суралцах боломжийг бүрдүүлж цаашид энэхүү өвийг ЮНЕСКО-н яаралтай хамгаалах Төлөөллийн жагсаалтад бүртгүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

2022 оны 6-р сарын 18-нд Анхдугаар наадамын шилдэг оролцогчид болон лимбэчдийн Гала тоглолтын мөн зохион байгуулав. Наадам болон Гала тоглолтын үйл явцыг фэйсбүүк зэрэг цахим сүлжээгээр шууд дамжуулан олон нийтэд нээлттэйгээр зохион байгуулсан болно.



**“УРТЫН ДУУ ЛИМБЭДЭХ УЛАМЖЛАЛТ АРГА БИТҮҮ АМЬСГАА -
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ-ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА
ХУРЛЫН**

2022.06.24

Соёлын өвийн үндэсний төв, Монголын лимбэчдийн холбоотой хамтран “Уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны 06-р сарын 18-ны өдөр Монголын лимбэдэх урлагийн өнөөгийн чиг хандлагыг тодорхойлоход хувь нэмэр оруулах зорилгоор эрдэм шинжилгээний бага хурлыг Соёлын өвийн үндэсний төвийн хурлын танхимд зохион байгуулж онол практикийн бага хурлын үйл явцыг фэйсбүүк лайв болон “zoom meeting” зэрэг цахим сүлжээгээр шууд дамжуулан олон нийтэд нээлттэйгээр зохион байгууллаа. Хурлын удирдан чиглүүлэгчээр “Байгаль, соёлын өвийг хамгаалах сан”-ийн тэргүүн, МУСГЗ, доктор \Ph.D.\, Н.Уртнасан, илтгэгчээр “Соёлын өвийн үндэсний төв”-ийн захирал, доктор (Ph.D) Г.Энхбат “Монгол ардын уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн хэрэгжилт үр дүн, СГЗ Г.Гонгоржав “Лимбэчин хүү” эртний лимбэний олдворын талаар”, Доктор (Ph.D.) С.Юндэнбат “Ахмад лимбэчдийн талаарх бидний ой санамж, дурсамж”, МЛХ-ны тэргүүн, доктор (Ph.D.), дэд профессор Ц.Цэвэгсүрэн “Уртын дуу лимбэдэх арга барилын онцлог, хэв маяг”, Улсын клиникийн нэгдсэн нэгдүгээр эмнэлэгийн эмч Ц.Доржсүрэн “Битүү амьсгаагаар хөгжимдөх явцын физиологийн онцлог”, Г.Нямжанцан “Монгол лимбэний хийц-бүтцийн тухай” зэрэг сэдвийн хүрээнд тус тус илтгэл хэлэлцүүлээ.

Үр дүн: Энэхүү эрдэм шинжилгээний хурлын үр дүнд тус өвийн онцлог ач холбогдлыг сурталчлах мөн үе үеийн ахмад лимбэчид, өвлөн суралцагчдыг олон нийтэд таниулан цаашид оршин тогтнох, судлагдахуун бий болгох, судалгааны эргэлтэд орох үндсийг тавьж “Монголын лимбэчид ба өвлөн уламжлагчид” номыг оролцогч нарт гардуулав. Түүнчлэн жил бүрийн 06 дугаар сарын 11-ний өдрийг “Лимбэчдын өдөр” болгож лимбэ хөгжмийг өвлүүлэх, лимбэчдийг алдаршуулах, битүү амьсгаа өвийг уламжлуулах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулж байхаар тогтлоо.

